

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/232-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум 2023 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитор: Д.Чулуунцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:Chuluuntsetsegd@audit.gov.mn">Chuluuntsetsegd@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

–	
1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. Аудитын тайлан	16-18
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	19-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газар



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II бар  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.13 № СГА-2023/202-НА СТА-ТЛЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2022 оны үйл ажиллагаанд 721,143.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, төсвийн гүйцэтгэл 99.7 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 2,487.2 мянган төгрөг буюу 0.3 хувиар хэмнэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2022 оны 06 дугаар сараас эхлэн “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем”-ийг нэвтрүүлж, цалин олгохтой холбогдуулан “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд албан хаагчдын мэдээллийг давхцалгүй, үнэн зөв оруулсан байна.

## **Аудитын гол асуудал**

Сэлэнгэ аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 70.1 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 13.3 хувийг тогтмол зардал эзэлж байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>66603894.93</b>	<b>70283126.16</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	728000.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	0.00	728000.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	728000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>66603894.93</b>	<b>69555126.16</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>32862701.00</b>	<b>33243701.01</b>
35110	Тусгай зориулалттай материал	32821701.00	33243701.01
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>33741193.93</b>	<b>36311425.15</b>
35410	Бичиг хэргийн материал	3090180.00	1341470.00
35420	Аж ахуйн материал	19161390.00	16335380.00
35460	Хүнсний материал	1971182.00	7317761.22
35470	Бусад хангамжийн материал	9518441.93	11316813.93
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1177312775.61</b>	<b>1173259750.38</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1177312775.61</b>	<b>1173259750.38</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>949308989.09</b>	<b>945455750.38</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	939612572.98	939612572.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	-72438599.68	-96701701.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	187738352.95	139500000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-171238352.83	-128499999.84
39205	Машин тоног төхөөрөмж	114477861.60	154106446.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-68855525.30	-83565925.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30232819.00	34704867.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17059647.51	-20280799.92
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	3746324.00	3746324.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	3912000.00	3912000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-818816.12	-1078033.12
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>228003786.52</b>	<b>227804000.00</b>
39301	Программ хангамж	6417692.31	6417692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6217905.79	-6417692.31
39303	Бусад биет бус хөрөнгө	227804000.00	227804000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1243916670.54</b>	<b>1243542876.54</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1243916670.54</b>	<b>1243542876.54</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1243916670.54</b>	<b>1243542876.54</b>
511	Засгийн газрын оруулсан капитал	345578539.48	345578539.48
51101	Өмч: - төрийн	345578539.48	345578539.48
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>328792680.71</b>	<b>328418886.71</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	327841933.58	328792680.71
51220	Тайлант үеийн үр дүн	950747.13	-373794.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	569545450.35	569545450.35
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1243916670.54</b>	<b>1243542876.54</b>

/Төгрөгөөр/

Эцсийн үлдэгдэл  
317147998  
065 955436

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/  
 754263883.01  
 25712983.01  
 754263883.01  
 25712983.01  
 754263883.01  
 25712983.01

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>715816636.00</b>	<b>754263883.01</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>54529836.00</b>	<b>25712983.01</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	54529836.00	25712983.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	54529836.00	25712983.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	1825700.00	872000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	52704136.00	24840983.01
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>661286800.00</b>	<b>728550900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	660786800.00	718750900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	660786800.00	718750900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	500000.00	9800000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500000.00	9500000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд нэмэлт орлого		300000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>714865888.87</b>	<b>754637677.01</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>714865888.87</b>	<b>754637677.01</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	709240583.38	753250692.75
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	495182753.20	491998426.17
210101	Үндсэн цалин	318027922.95	330338871.96
210102	Нэмэгдэл	156341730.25	131199279.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20813100.00	24125000.00
210104	Урамшуулал		6335275.11
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос НДШ</b>	11346200.00	11143620.04
210201	Тэтгэврийн даатгал	1487808.34	568332.49
210202	Тэтгэмжийн даатгал	131889.68	53490.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	164861.99	66862.63
210204	Ажилгүйдлийн даатгал	32972.41	13372.56
210205	Эрүүл мэндийн даатгал	9528667.58	10441562.23
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	60629257.81	95788199.90
210301	Гэрэл, цахилгаан	11755410.10	11546958.90
210302	Түлш, халаалт	41544442.00	58126960.00
210303	Цэвэр, бохир ус	7329405.71	26114281.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23222558.50	31109466.13
210401	Бичиг хэрэг	5614992.00	5693510.00
210402	Тээвэр, шатахуун	10668500.00	9048996.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1243250.00	1091575.13
210405	Хог хаягдал зайлуулах, устгал, ариутгал	134000.00	210000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5561816.50	15065385.00

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	39876373.40	43131008.28
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	761400.00	870700.00
210502	Хоол, хүнс	38817440.20	40234620.28
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	297533.20	2025688.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18708200.00	24820100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		195000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	252000.00	264600.00
210604	Урсгал засвар	18456200.00	24360500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	500000.00	426000.00
210702	Дотоод албан томилолт	500000.00	426000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, төлбөр, хураамж</b>	4376427.00	3430214.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1881100.00	1869574.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	825200.00	421724.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	234000.00	110000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800000.00	671500.00
210807	Газрын төлбөр	204127.00	357416.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	55398813.47	51403658.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3274128.00	3250000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52124685.47	48153658.23
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5625305.49	1386984.26
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1848000.00	419980.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1848000.00	419980.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт</b>	3466505.49	967004.26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3466505.49	967004.26
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>950747.13</b>	<b>-373794.00</b>



## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/  
 4217143998  
 25436

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>664540500.00</b>	<b>729183895.74</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3253700.00</b>	<b>1600000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3253700.00</b>	<b>1600000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1825700.00	872000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1825700.00	872000.00
120009	Бусад орлого	1428000.00	728000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>661286800.00</b>	<b>727583895.74</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>660786800.00</b>	<b>717783895.74</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	660786800.00	717783895.74
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>500000.00</b>	<b>9800000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500000.00	9500000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	300000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>664575500.00</b>	<b>728455895.74</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>664575500.00</b>	<b>728455895.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>658950194.51</b>	<b>728035915.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>496610753.20</b>	<b>492726426.17</b>
210101	Үндсэн цалин	319455922.95	330338871.96
210102	Нэмэгдэл	156341730.25	151009779.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20813100.00	5042500.00
210104	Урамшуулал	0.00	6335275.11
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>11346200.00</b>	<b>11143620.04</b>
210201	Тэтгэврийн даатгал	1487808.34	568332.49
210202	Тэтгэмжийн даатгал	131889.68	53991.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	164861.99	66361.24
210204	Ажилгүйдлийн даатгал	32972.41	13372.56
210205	Эрүүл мэндийн даатгал	9528667.58	10441562.23
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>60629257.81</b>	<b>95788199.90</b>
210301	Гэрэл, цахилгаан	11755410.10	11546958.90
210302	Түлш, халаалт	41544442.00	58126960.00
210303	Цэвэр, бохир ус	7329405.71	26114281.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20971418.50</b>	<b>27983425.63</b>
210401	Бичиг хэрэг	5136842.00	5354050.00
210402	Тээвэр, шатахуун	9637500.00	9048996.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1269750.00	992795.13
210404	Ном, хэвлэл	0.00	300000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	134000.00	210000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4793326.50	12077584.50
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>38618990.00</b>	<b>46407650.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	697200.00	829700.00

210502	Хоол, хүнс	37921790.00	45577950.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>22949700.00</b>	<b>46512100.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4241500.00	22023000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	252000.00	264600.00
210604	Урсгал засвар	18456200.00	24224500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>500000.00</b>	<b>426000.00</b>
210702	Дотоод албан томилолт	500000.00	426000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, төлбөр, хураамж</b>	<b>4472627.00</b>	<b>3638294.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1977300.00	2077654.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	825200.00	421724.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	234000.00	110000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800000.00	671500.00
210807	Газрын төлбөр	204127.00	357416.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2851248.00</b>	<b>3410200.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2851248.00	3410200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5625305.49</b>	<b>419980.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1848000.00</b>	<b>419980.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1848000.00	419980.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-35000.00</b>	<b>728000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-35000.00</b>	<b>728000.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>728000.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,578,539.48	569,642,613.17	327,744,770.76	1,242,965,923.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	34,596.82	34,596.82
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	345,578,539.48	569,642,613.17	327,779,367.58	1,243,000,520.23
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-34,596.82	0.00	-34,596.82
C07	Тайлант үеийн үр дүн			950,747.13	950,747.13
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,578,539.48	569,608,016.35	328,730,114.71	1,243,916,670.54
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,578,539.48	569,573,419.53	329,680,861.84	1,243,916,670.54
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	345,578,539.48	569,608,016.35	328,730,114.71	1,243,916,670.54
D08	Тайлант үеийн үр дүн			-373,794.00	-373,794.00
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,578,539.48	569,608,016.35	328,356,320.71	1,243,542,876.54

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Мөнгө, хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	721143000.00	718655895.74	2487104.26	99.7
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	721143000.00	718655895.74	2487104.26	99.7
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	720723000.00	718235915.74	2487084.26	99.7
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	492726800.00	492726426.17	373.83	100.0
210101	Үндсэн цалин	317999500.00	330338871.96	-12339371.96	103.9
210102	Нэмэгдэл	170524900.00	151009779.10	19515120.90	88.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2570400.00	5042500.00	-2472100.00	196.2
210104	Урамшуулал	1632000.00	6335275.11	-4703275.11	388.2
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос НДШ</b>	11246200.00	11143620.04	102579.96	99.1
210201	Тэтгэврийн даатгал	0.00	568332.49	-568332.49	-
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	53991.52	-53991.52	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	66361.24	-66361.24	-
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	13372.56	-13372.56	-
210205	Эрүүл мэндийн даатгал	11246200.00	10441562.23	804637.77	92.9
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	95788200.00	95788199.90	0.10	100.0
210301	Гэрэл, цахилгаан	13556800.00	11546958.90	2009841.10	85.2
210302	Түлш, халаалт	63815100.00	58126960.00	5688140.00	91.1
210303	Цэвэр, бохир ус	18416300.00	26114281.00	-7697981.00	141.8
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27683600.00	27683425.63	174.37	100.0
210401	Бичиг хэрэг	5406100.00	5354050.00	52050.00	99.0
210402	Тээвэр, шатахуун	17158500.00	9048996.00	8109504.00	52.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3092700.00	992795.13	2099904.87	32.1
210405	Хог хаягдал зайлуулах, устгал, ариутгал	272500.00	210000.00	62500.00	77.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1753800.00	12077584.50	-10323784.50	688.7
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	46413100.00	46407650.00	5450.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	829700.00	829700.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	45583400.00	45577950.00	5450.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	38627700.00	37012100.00	1615600.00	95.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	13665200.00	12523000.00	1142200.00	91.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	264600.00	264600.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	24697900.00	24224500.00	473400.00	98.1
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	445400.00	426000.00	19400.00	95.6
210702	Дотоод албан томилолт	445400.00	426000.00	19400.00	95.6
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр, хураамж</b>	4381800.00	3638294.00	743506.00	83.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамж	2094400.00	2077654.00	16746.00	99.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	363100.00	0.00	363100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	693500.00	421724.00	271776.00	60.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	196700.00	110000.00	86700.00	55.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	672400.00	671500.00	900.00	99.9

210807	Газрын төлбөр	361700.00	357416.00	4284.00	98.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3410200.00	3410200.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3410200.00	3410200.00	0.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	420000.00	419980.00	20.00	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	420000.00	419980.00	20.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420000.00	419980.00	20.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	721143000.00	718655895.74	2487104.26	99.7
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	718750900.00	717783895.74	967004.26	99.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	718750900.00	717783895.74	967004.26	99.9
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	2392100.00	872000.00	1520100.00	36.5
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2392100.00	872000.00	1520100.00	36.5
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		0.00		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		728000.00		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00		
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	36.00	35.00		97.2
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	33.00		97.1
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00		100.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>36.0</b>	<b>35.0</b>		97.2
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	35.00	35.00		100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	1.00	0.00		

### 3.5.3 Нэмэлт төсөв

/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>9800000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>9800000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>9800000.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>300000.00</b>
210404	Ном, хэвлэл	0.00	300000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>9500000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	9500000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>500000.00</b>	<b>9800000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>500000.00</b>	<b>9800000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500000.00	9500000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	300000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		728000.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын /Сэлэнгэ аймаг дахь ШШГТ/ нь “Шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дэлхий нийтээр мөрдөж байгаа эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлж, олон улсын жишигт хүргэх, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр бүрийн биелэлтийг хангах, үйлчлүүлэгч, хэрэглэгчид шуурхай үйлчлэх” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.



Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалах энэхүү үүргийг бүрэн хэрэгжүүлэх,
- Цагдан хорих, таслан сэргийлэх үйл ажиллагааг хүний эрхийг дээдлэн, хүний амьдрах эрүүл ахуйн шаардлага, стандартад нийцүүлэн хуулийн дагуу хэрэгжүүлж ажиллах,
- Хорих болон хорихоос өөр төрлийн ялыг албадан эдлүүлэх, сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, эрүүгийн ялын зорилтыг хангах,
- Иргэний, захиргааны зөрчлийн болон эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын анги, салбар нэгжийн барилга байгууламж, ахуй нөхцөлийг сайжруулах.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 06 дугаар сарын 03, 28-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ШШГЕГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хяналт тавьж ажилладаг боловч тайлант онд дотоод хяналт шалгалт, аудит хийгдээгүй бөгөөд байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд ШШГЕГ-ын Хяналт, шалгалт, аюулгүй байдлын газраас хяналт, шалгалт хийгдсэн байна.

Тус хяналт шалгалтаар авто машинуудын 100 км-т зарцуулах шатахууны зарцуулалтыг тогтоогоогүй, жолоочийн тооцооны хуудсанд автомашин ашиглагчийн гарын үсэг зуруулж тооцоог бодоогүй, ажлын цаг ашиглалтын бүртгэлийг хянаж цалин бодоогүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ШШГЕГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар ШШГЕГ болон түүний харьяа байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн ба тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 373.7 мянган төгрөгөөр буюу 0.03 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	728.0	728.0
Бараа материал	66,603.8	69,555.1	2,951.3
Үндсэн хөрөнгө	1,177,312.7	1,173,259.7	-4,053.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,243,916.5</b>	<b>1,243,542.8</b>	<b>-373.7</b>
Өр төлбөр	-	-	-
<b>Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/</b>	<b>1,243,916.7</b>	<b>1,243,542.8</b>	<b>-373.7</b>

Мөнгөн хөрөнгө данс 728.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 2022 оны цалингийн сангийн хэмнэлтийг ШШГЕГ-ын 2021 оны А/11 дугаар тушаалыг үндэслэн Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын төрийн санд байршиж буй ахмадын сангийн дансанд шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 69,555.1 мянган төгрөг болж 2,951.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 98,696.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон ШШГЕГ-аас 2,013.4 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авч, 97,759.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,500,303.9 мянган төгрөг болж 13,637.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 11,773.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, 22,827.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг ШШГЕГ болон анги салбараас үнэ төлбөргүй хүлээн авсан болон ТӨБЗГ-ын даргын 2022 оны А/693 дугаар тушаалаар 48,238.3 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг акталж, данс бүртгэлээс хассанаас голлон шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,234,042.8 мянган төгрөг болж 373.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон зардлыг 749,247.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 28,104.1 мянган төгрөгөөр бууруулж 721,143.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Үүнд эд хогшил худалдан авах зардал 25,000.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 3,104.1 мянган төгрөгөөр буурч батлагдсан нь голлон нөлөөлсөн байна.



### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 721,143.0 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс олгох санхүүжилтээр 718,750.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 2,392.1 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 718,750.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 872.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн 718,655.9 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 967.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 718,655.9 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь үйл ажиллагааны орлого 1,520.1 мянган төгрөгөөр тасарснаас шалтгаалан эд хогшил, урсгал засварын зардлын 1,615.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний, төлбөр хураамжийн зардлын 743.5 мянган төгрөг, албан томилолтын зардлын 25.4 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлын 102.6 мянган төгрөгийг тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	709,761.60	708,811.40	950.20	99.9
2	Туслах үйл үйл ажиллагаа	2,392.10	872.00	1,520.10	36.5
3	Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа	7,394.70	7,394.70	-	100.0
4	Холбооны суваг ашигласны төлбөр	1,174.60	1,157.80	16.80	98.6
5	Нэг удаагийн тэтгэмжийн зардал	420.00	419.90	0.10	100.0
	<b>Дүн</b>	<b>721,143.0</b>	<b>718,655.8</b>	<b>2,487.2</b>	<b>99.7</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс камержуулах ажлыг санхүүжүүлэхээр 9,500.0 мянган төгрөг, аймгийн Номын сангаас Шилдэг номын сантай байгууллагаар шалгарсны шагналын 300.0 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.



Гүйцэтгэлээр хорих өрөөнд 25 камер, гадна хашаанд 10 камер, 2 хянах дэлгэц, Хүүхэд залуучуудын нэвтэрхий толь-3, Монголын нууц товчоо зэрэг номуудыг 300.0 мянган төгрөгөөр тус тус худалдан авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, мөнгөн урамшуулал олгож байх, автомашины шатахуун зарцуулалтын нормыг бодитоор шинэчлэн тогтоож, анхан шатны баримтыг үнэн зөв бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх гэсэн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 1/55 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 715,816.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,158.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ШШГЕГ-ын даргын 2022 оны 02 дугаар “Төсвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” албан даалгавар, Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын даргын 2022 оны 06/41 дугаар “Төсвийн талаар авах зарим арга хэмжээний тухай”, 06/137 дугаар “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” албан бичгийг хэрэгжүүлж, төсвийг зохистой удирдаж, авлага, өглөг үүсгэлгүй ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллээс 9,500.0 мянган төгрөгийн /цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ/ 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 54,367.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй, үүрэг гүйцэтгэж буй албан хаагчид олгох хүнсний нормыг баримтлаагүйгээс 2,978.6 мянган төгрөгийн хүнс илүү зарцуулсан 2 зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	57,345.9	2	57,345.9	100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>57,345.9</b>	<b>2</b>	<b>57,345.9</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

**4.6.1** Тайлант жилийн төсөвт тусгагдаж, батлагдаагүй байхад ШШГЕГ-ын 2021 оны А/11 дугаар тушаалыг үндэслэн цалингийн зардлын батлагдсан төсвөөс 728.0 мянган төгрөгийг Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын ахмадын сангийн дансанд шилжүүлсэн нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Энэ нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна.

**4.6.2.** Байгууллагын эзэмшилд байгаа хуучин албан конторын барилгыг албан хаагчдад түрээслүүлэх замаар 2,392.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч уг барилгын дулаан хангамжид гэмтэл гарч түрээслүүлэх боломжгүй гэнэтийн нөхцөл байдал үүссэний улсаас гүйцэтгэлээр 872.0 мянган төгрөг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг 1,520.1 мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Дараагийн аудитаар өөрийн орлогыг тооцоо судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөсөн эсэх, төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэхийг авч үзэх шаардлагатай.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт **2,590.0** мянган төгрөгийн зөрчил илэрч, зөвлөмж өглөө.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт:** Сэлэнгэ аймаг дахь ШШГГ нь төрийн албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр үнэлж, урамшуулал олгож үзжээг хагас, бүтэн жилийн эцэст төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогын ажлыг хангалттай гүйцэтгэсэн, тэмцээн уралдаанд амжилттай оролцсон гэх үндэслэлээр цөөн албан хаагчдад үндсэн цалингийн 20-80 хувийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 1.2-т “Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид...мөнгөн урамшуулал олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Төрийн албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, мөнгөн урамшуулал олгож байх.

#### **2. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

**2.1 Илрүүлэлт:** Олон жил ашиглагдаж байгаа хуучин авто машинуудын шатахууны зарцуулалтын норм нормативыг тогтоогоогүй, жолоочийн тооцооны хуудсыг холбогдох маягт аргачлалаар хөтлөөгүй, шатахуун зарцуулалтын тооцоог бодолгүйгээр нийт **2,590.0** мянган төгрөгийн шатахууныг олгож, бүртгэл тайланд зардлаар тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 1.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Автомашины шатахуун зарцуулалтын нормыг бодитоор шинэчлэн тогтоож, анхан шатны баримтыг үнэн зөв бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
							Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												



### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг төсөвт тусган олгоогүй	1						1					
Шатахуун зарцуулалтын норм нормативын дагуу зарцуулалтын тооцоог бодолгүйгээр зардлаар бүртгэж тайлагнасан	1	2,590.0					1	2,590.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2,590.0</b>					<b>2</b>	<b>2,590.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
<b>Дүн</b>												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
<b>Дүн</b>												
<b>Нийт дүн</b>												